

“МОНГОЛЫН ЗАЛУУ ЭРДЭМТДИЙН ХОЛБОО” /ТББ/-ын дүрэм

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү дүрмийн зорилго нь “Монголын залуу эрдэмтдийн холбоо” ТББ (цаашид Холбоо гэх)-ны үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл, бүтэц, хяналтын тогтолцоо, удирдлага, санхүүжилт, өөрчлөх болон татан буугдах үндэслэл зэргийг тогтооход оршино.
- 1.2 Монголын Залуу Эрдэмтдийн Холбоо нь залуу судлаач, багш, эрдэмтдийн санаачлагаар үүсгэн байгуулагдсан, Монгол улсын хуулийн дагуу эрх бүхий байгууллагад бүртгэгдсэн, гишүүдийнхээ эрх ашгийг илэрхийлэх, гишүүдэд үйлчилдэг, өөрөө өөрийгөө удирдах зарчимтай, ашгийн төлөө бус, хуулийн этгээд мөн.
- 1.3 Холбоо нь Монгол Улсын Үндсэн Хууль, Төрийн бус байгууллагын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжууд болон энэхүү дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.
- 1.4 Холбоо нь хуулийн этгээдийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
- 1.5 Холбооны үйл ажиллагаа төрийн байгууллага, улс төрийн нам, эвсэл болон хөндлөнгийн аливаа этгээдээс хараат бус байна.
- 1.6 Холбоог товчоор “МЗЭХ”, англиар “Mongolian Young Scientist’s Association” гэнэ.
- 1.7 Холбооны хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Багшийн Сургуулийн V байр, 310 тоот. Утас: +976 (11) 311013. Цахим хуудас: www.mysa.mn
- 1.8 Холбоо нь өөрийн бэлгэдэл, туг далбаа, тамга тэмдэгтэй байх ба албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.9 Холбоо нь банкинд харилцах болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад данстай байна.
- 1.10 Энэхүү дүрмийг баталсан өдөр буюу 2004 оны 04 сарын 05-ны өдрийг Холбоог үүсгэн байгуулагдсанд тооцно.
- 1.11 Холбоо нь гадаад, дотоодод өөрийн салбар, үйл ажиллагааны нэгж, төлөөлөлтэй байж болно.
- 1.12 Холбооны салбар, нэгжүүд нь холбогдох хууль, тогтоомж болон энэ дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

- 1.13 Холбооны үйл ажиллагаа нь олон нийт, бүх гишүүд болон холбогдох төр захиргаа, ивээн тэтгэгч байгууллагад ил тод, нээлттэй байна.

ХОЁР. Зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл

- 2.1 Холбооны эрхэм зорилго нь дотоод, гадаадад эрдэм шинжилгээний ажил эрхэлж буй Монгол Улсын иргэн залуу судлаач, эрдэмтдэд бүх талын дэмжлэг үзүүлэх, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах, эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлд залгамж халаа бэлтгэх, гадаад орнуудын залуу эрдэмтэд, холбоодтой хамтран ажиллах, Монгол улсын шинжлэх ухаан, технологийн хөгжилд мэдлэгийн хөрөнгө оруулалт хийхэд оршино.
- 2.2 Холбоо нь зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлээр гишүүддээ чиглэсэн үйл ажиллагаа явуулна:
- 2.2.1 Судлаач, эрдэмтэн залуучуудын судалгааны ажлыг дэмжин туршлага солилцуулах, үндэсний болон олон улсын хэмжээнд эрдэм шинжилгээний хурал, чуулга уулзалт, сургалт, семинар зохион байгуулах;
- 2.2.2 Холбооны гишүүдийг мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэн дотоод, гадаадад сурч ажиллахад дэмжлэг үзүүлэх;
- 2.2.3 Үйл ажиллагааныхаа чиглэлээр төрийн ба төрийн бус байгууллагууд, хувь хүмүүстэй үндэсний болон олон улсын хэмжээнд хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, тэднээс санхүүгийн болон мэдээлэл, мэргэжлийн туслалцаа, хандив тусламж авах;
- 2.2.4 Салбар бүрийн залуу судлаач, эрдэмтдийн мэдлэг, туршлага, чадвар, арга барилыг нэгтгэн баг бүрдүүлж судалгаа, сургалт, үзэсгэлэн, яармагийг зохион байгуулах;
- 2.2.5 Зорилгод нийцсэн бусад арга хэмжээг зохион байгуулах.
- 2.3 Холбооны дүрэмд тусгагдаагүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ГУРАВ. Гишүүнчлэл

- 3.1 Холбооны эрхэм зорилго, дүрэм, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хүлээн зөвшөөрч буй өмчийн бүх хэлбэрийн эрдэм шинжилгээний хүрээлэн, төв болон үйлдвэр, аж ахуйн нэгж, их дээд сургуулиудад ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан, судлаач, багш, оюутан сайн дурын үндсэн дээр тус байгууллагад гишүүнээр элсэнэ.
- 3.2 Холбооны гишүүнчлэл нь гишүүн, хүндэт гишүүн гэсэн хэлбэртэй байна.
- 3.3 Гишүүн, түүний эрх, үүрэг:
- 3.3.1 Холбооны дүрмийг хүлээн зөвшөөрч, тухайн жилийн татвараа төлсөн хувь хүнийг холбооны гишүүн гэнэ;

- 3.3.2 Тухайн жилийн гишүүний татварын хэмжээг Удирдах зөвлөлөөс (цаашид УЗ гэнэ) тогтооно;
 - 3.3.3 Гишүүн нь Бүх гишүүдийн хурал (цаашид БГХ гэнэ)-д оролцох, санал, санаачлага гаргах эрхтэй;
 - 3.3.4 Гишүүн нь холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, Холбооны зорилгыг хэрэгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулна;
 - 3.3.5 Гишүүн нь холбооны үйл ажиллагааны талаар санал хүсэлт гаргах, дүрэм журмын хүрээнд шийдвэрлүүлэх эрхтэй;
 - 3.3.6 Гишүүн нь холбооны дүрмийг дагаж мөрдөнө.
- 3.4 Холбооны зорилгод нийцсэн, залуусын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан болон санхүүгийн чадавхийг өргөжүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр тус байгууллагад хандив, тусламж үзүүлсэн хувь хүн, байгууллага нь Холбооны хүндэт гишүүн болно.
- 3.5 Гишүүний татвар, хүндэт гишүүний хандивыг Холбооны үйл ажиллагааг идэвхжүүлэх, байгууллагыг бэхжүүлэх, чадавхижуулах, гишүүдийн идэвхи санаачлагыг нэмэгдүүлэхэд зориулна.

ДӨРӨВ. Холбооны бүтэц, зохион байгуулалт

- 4.1 Холбоо нь дараах бүтэцтэй байна:
- 4.1.1 Удирдах зөвлөл (цаашид УЗ гэнэ);
 - 4.1.2 Ерөнхийлөгч;
 - 4.1.3 Зөвлөх танхим (цаашид ЗТ гэнэ) ба Ерөнхий Зөвлөх (цаашид ЕЗ гэнэ);
 - 4.1.4 Хяналтын зөвлөл (цаашид ХЗ гэнэ);
 - 4.1.5 Ерөнхий нарийн бичгийн дарга (цаашид ЕНБД);
 - 4.1.6 Гүйцэтгэх захирал (цаашид ГЗ гэнэ) болон Гүйцэтгэх алба (цаашид ГА гэнэ).
- 4.2 Холбооны эрх барих байгууллага нь Удирдах зөвлөл бөгөөд УЗ-ийн дарга нь холбооны Ерөнхийлөгч байна.
- 4.3 Холбооны үйл ажиллагааны ойрын болон хэтийн зорилго, чиглэлийг тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх байгууллага нь Зөвлөх танхим ба танхимыг Ерөнхий зөвлөх тэргүүлнэ.
- 4.4 Холбооны санхүү, үйл ажиллагаа нь энэхүү дүрэм болон бусад журамд нийцэж буй эсэхэд хяналт тавих эрх бүхий хараат бус байгууллага нь Хяналтын зөвлөл байна.
- 4.5 Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэгч байгууллага нь Гүйцэтгэх алба бөгөөд түүнийг Гүйцэтгэх захирал удирдана.
- 4.6 Холбоо нь бүтцэндээ шинжлэх ухааны бүх чиглэлүүд болон технологи, инновацийн чиглэлээр салбар холбоодтой байж болно.

- 4.7 Салбар холбоодыг тухайн салбарын залуу эрдэмтдийн холбооны удирдах зөвлөлөөр үүсгэн байгуулж, хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлсэн байна.
- 4.8 Салбар холбоодын дүрэм, үйл ажиллагааны зорилго, хэлбэр нь Холбооны дүрэмд нийцсэн байна.
- 4.9 Салбар холбоодын удирдах зөвлөлөөс тухайн салбарын тэргүүнийг сонгож, Холбооны Ерөнхийлөгч тэргүүнийг батламжилна.

ТАВ. Удирдах Зөвлөлийн эрх, хэмжээ

- 5.1 Удирдах зөвлөл нь есөөс доошгүй сондгой тооны гишүүнтэй байх ба Холбооны Ерөнхийлөгч, салбар холбоодын тэргүүн, ЕЗ, ЕНБД нар болон бусад гишүүдээс бүрдэнэ.
- 5.2 УЗ-ийн дарга нь Холбооны ерөнхийлөгч байна.
- 5.3 УЗ-ийг улиралд нэгээс доошгүй удаа жилд 4-с доошгүй удаа хуралдуулна.
- 5.4 УЗ-ийн гишүүдийн ирц 51 хувиас дээш тохиолдолд хуралдаж хурлын шийдвэрийг хүчин төгөлдөр гэж үзнэ. Хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд тэгш эрхтэйгээр саналаа илээр, хувь хүнтэй холбоотой асуудлыг нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. Хурлын шийдвэр нь УЗ-ийн тогтоол байна.
- 5.5 УЗ-ийн хуралд ГЗ, ГА, ХЗ-ийн гишүүд ажиглагчаар оролцох эрхтэй.
- 5.6 УЗ-ийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх бөгөөд хурлын дэгийг УЗ-ийн дарга боловсруулан УЗ-ийн хурлаар батлан мөрдүүлнэ.
- 5.7 УЗ-ийн гишүүд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд албан ёсоор удирдах зөвлөлд урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авах бөгөөд уг хуралд салбар холбооны гүйцэтгэх захирал тухайн салбар холбоог төлөөлж, хэлэлцэж буй асуудалд саналын эрхтэйгээр оролцоно.
- 5.8 УЗ-ийн хуралд хэлэлцэх асуудал, холбогдох мэдээллийг хурлын товоос 3-аас доошгүй хоногийн өмнө УЗ-ийн гишүүдэд хүргэнэ.
- 5.9 УЗ-ийн хурлаас асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 5.10 УЗ нь дараах асуудлыг хэлэлцэн, шийдвэр гаргана. Үүнд:
 - 5.10.1 Холбооны дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;
 - 5.10.2 Холбооны урт ба дунд хугацааны бодлого, зорилт, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;
 - 5.10.3 Холбооны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, тайланг хэлэлцэх;

- 5.10.4 Холбооны өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар Ерөнхийлөгч болон түүний албаны эрх, хэмжээг тогтоох;
 - 5.10.5 ХЗ-ийн гишүүдийг сонгох, батлах;
 - 5.10.6 Холбооны жилийн үр дүн, санхүүгийн тайлан болон ЕНБД, ГЗ, ГА-ны тайланг хэлэлцэх;
 - 5.10.7 Салбар холбоодын ажлын үр дүнг хэлэлцэх;
 - 5.10.8 ХЗ-өөс ирүүлсэн санал, асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх;
 - 5.10.9 Тухайн жилийн гишүүдийн татварын хэмжээг шинэчлэн тогтоох;
- 5.11 УЗ-ийн гишүүд холбооны нэр ба эд хөрөнгийг хувийн ашиг олох зорилгоор ашиглахыг хориглоно.
- 5.12 УЗ-ийн гишүүн нь бүрэн эрхийнхээ хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх тохиолдолд 30 хоногийн дотор нөхөн сонгогдсон байна.

**ЗУРГАА. Удирдах Зөвлөлийн дарга бөгөөд
Холбооны ерөнхийлөгчийн эрх хэмжээ**

- 6.1 УЗ-ийн дарга бөгөөд Ерөнхийлөгч /цаашид Ерөнхийлөгч гэх/ нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна:
- 6.1.1 Холбооны хэтийн болон ойрын зорилт, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж УЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх;
 - 6.1.2 Холбооны үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;
 - 6.1.3 Дотоод болон гадаадад холбоог төлөөлөх;
 - 6.1.4 УЗ-ийн хуралдааныг даргалах;
 - 6.1.5 Холбооны өмч хөрөнгийг энэхүү дүрмийн 5.10.4-т заасны дагуу захиран зарцуулах болон санхүүгийн баримт бичигт 1-р гарын үсэг зурах;
 - 6.1.6 Холбооны ЕНБД, ГЗ, Зохицуулагчийг томилох;
 - 6.1.7 ЕНБД, ГЗ, Зохицуулагч нартай гэрээ байгуулах, ажил үүрэгт хяналт тавих;
 - 6.1.8 ГА-ын бүтэц зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийг УЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;
 - 6.1.9 Салбар холбооны тэргүүнийг тухайн салбар холбооны УЗ-ийн тогтоол, хурлын тэмдэглэлийг үндэслэн батламжлах;
 - 6.1.10 Цаг үеийн асуудлаар УЗ-ийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, санал гаргах;
 - 6.1.11 Холбооны жилийн үр дүн, санхүүгийн тайланг УЗ-д хэлэлцүүлэх.
- 6.2 Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна. Ерөнхийлөгчийг 1 удаа улируулан сонгож болно.
- 6.3 Холбооны Ерөнхийлөгч нь эрдмийн зэрэг хамгаалсан (Ph.D) байна

- 6.4 Ерөнхийлөгч нь бүрэн эрхийнхээ хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх тохиолдолд 30 хоногийн дотор нөхөн сонгогдсон байна.

ДОЛОО. Зөвлөх танхим

- 7.1 Холбооны хүндэт гишүүн нь Холбооны ЗТ-ийн гишүүн мөн.
- 7.2 ЗТ-ийн гишүүдийн тоог хязгаарлахгүй.
- 7.3 ЗТ-ийн уулзалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.
- 7.4 ЗТ-ийн үйл ажиллагааг холбооны ЕЗ удирдана.
- 7.5 ЕЗ-ийг УЗ-өөс томилон ажиллуулах ба ЕЗ-ийн бүрэн эрхийн хугацаа нь 2 жил байна.
- 7.6 ЕЗ нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна:
- 7.6.1 ЕЗ нь удирдах зөвлөлийн гишүүн байна;
 - 7.6.2 Холбооны урт ба богино хугацааны бодлого, цаашдын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход Ерөнхийлөгчид зөвлөх;
 - 7.6.3 Шинжлэх ухаан технологийн бодлого үйл ажиллагааны талаар зөвлөгөө үзүүлэх;
 - 7.6.4 Инноваци болон бусад чиглэлээр бодлогын зөвлөгөө үзүүлэх;
- 7.7 ЕЗ нь бүрэн эрхийнхээ хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөөлөгдөх тохиолдолд 30 хоногийн дотор нөхөн сонгогдсон байна.

НАЙМ. Хяналтын зөвлөл

- 8.1 Холбооны ХЗ нь энэхүү дүрмийн биелэлт, УЗ-ийн тогтоол, түүний хэрэгжилтэнд хяналт тавих эрх бүхий хараат бус Холбооны нэгж мөн.
- 8.2 ХЗ-ийг УЗ-өөс томилох бөгөөд бүрэн эрхийн хугацаа 2 жил байна.
- 8.3 ХЗ нь 3 гишүүнтэй байх ба ХЗ-ийн даргыг хяналтын гишүүд нь дундаасаа нэр дэвшүүлж, нууц санал хураалтаар сонгоно.
- 8.4 ХЗ олонхийн саналаар шийдвэр гаргана.
- 8.5 ХЗ-ийн гишүүнийг ажлаас чөлөөлөх, нөхөн сонгох асуудлыг удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.
- 8.6 ХЗ-ийн гишүүн нь УЗ-өөс хараат бус байж, хуулийг дээдлэн гагцхүү Холбооны дүрмэнд захирагдана.
- 8.7 ХЗ-ийн гишүүн нь Холбооны болон салбар холбооны сонгуульд гишүүний үүргийг хавсрахгүй.

8.8 ХЗ-ийн гишүүн нь байгууллагын дотоод мэдээ, мэдээллийг чанадлан нууцлах үүрэгтэй.

8.9 ХЗ нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

8.9.1 ХЗ-ийн гишүүн нь УЗ-ийн хуралд ажиглагчаар оролцох, зөвлөх эрхтэй;

8.9.2 ХЗ нь үйл ажиллагааныхаа журмыг Холбооны дүрэмд нийцүүлэн боловсруулж, УЗ-өөр батлуулна.

ЕС. Ерөнхий нарийн бичгийн дарга

9.1 ЕНБД-ын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, урамшуулал зэрэг асуудлыг Ерөнхийлөгчтэй байгуулсан гэрээгээр тогтооно.

9.2 ЕНБД-ыг Холбооны Ерөнхийлөгч гишүүдийн дундаас 2 жилийн хугацаатайгаар томилон ажиллуулна.

9.3 ЕНБД нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

9.3.1 Холбооны Ерөнхийлөгчийн эзгүйд түүний эрх, үүргийг орлон гүйцэтгэнэ;

9.3.2 Холбооны судалгаа хөгжлийн чиг үүргийг хэрэгжүүлэх;

9.3.3 Гадаад харилцааг хөгжүүлэх, олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулахад санаачлага гарган ажиллах;

9.3.4 Салбар холбоодуудын үйл ажиллагаа, арга хэмжээг чиглүүлэх, дэмжих, салбар холбоодын тэргүүн болон гүйцэтгэх захирлуудыг удирдамжаар ханган хамтран ажиллах;

9.3.5 Шинжлэх ухааныг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх, залуу эрдэмтэн судлаачдад чиглэсэн шилдэг төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг санаачлах, хэрэгжүүлэх;

9.3.6 Холбооны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ГЗ-тай хамтран боловсруулах, тайлагнах;

9.3.7 УЗ-ийг мэдээллээр хангах, УЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, шийдвэрийн төслийг боловсруулан танилцуулах.

9.4 Холбооны ЕНБД нь магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэг цолтой байна.

АРАВ. Гүйцэтгэх захирал

10.1 Гүйцэтгэх захирлын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлага, урамшуулал зэрэг асуудлыг Ерөнхийлөгчтэй байгуулсан гэрээгээр тогтооно.

10.2 ГЗ -ыг Холбооны Ерөнхийлөгч гишүүдийн дундаас 2 жилийн хугацаатайгаар томилон ажиллуулна.

10.3 ГЗ нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна:

- 10.3.1 Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хүн, хүч, техник тоног төхөөрөмжийн нөөцийг зохистой бүрдүүлэх;
- 10.3.2 Холбооны бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэх, санхүүжилтын эх үүсвэр бий болгох;
- 10.3.3 Холбооны үйл ажиллагааг тасралтгүй сайжруулан ажиллах;
- 10.3.4 Холбооны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ЕНБД-тай хамтран боловсруулах, тайлагнах;
- 10.3.5 Дотоодын шинжлэх ухаан, технологи, бизнесийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан үйл ажиллагаа явуулах, санаачлага гарган ажиллах.

АРВАН НЭГ. Гүйцэтгэх алба

- 11.1 Гүйцэтгэх алба нь холбооны зохицуулагч болон салбар холбоодын гүйцэтгэх захирал нараас бүрдэх ба тэдгээрийн ажил үүргийн хуваарилалт нь энэ дүрмийн 6.1.8-д заасны дагуу зохицуулагдана.
- 11.2 Салбар холбоодын гүйцэтгэх захирлуудын эрх, үүрэг нь тухайн салбар холбоодын дүрмээр зохицуулагдана.
- 11.3 Зохицуулагчийн эрх, үүрэг, хариуцлага, урамшуулал зэрэг асуудлыг Ерөнхийлөгчтэй байгуулсан гэрээгээр тогтооно.
- 11.4 Зохицуулагчийг 2 жилийн хугацаатайгаар томилон ажиллуулна.
- 11.5 Зохицуулагч нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна:
 - 11.5.1 Холбооны өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэх албыг нэгдмэл удирдлагаар ханган ажиллах;
 - 11.5.2 Холбооны хэвлэл мэдээлэл болон олон нийтийн байгууллагуудтай харилцах;
 - 11.5.3 Гадаад болон дотоодын шинжлэх ухаан технологи, бизнесийн байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан үйл ажиллагаа явуулах;
 - 11.5.4 Гишүүдийг чадавхижуулахад чиглэсэн үйл ажиллагааг хариуцах;
 - 11.5.5 УЗ-ийг мэдээллээр хангах УЗ-ийн хуралдааныг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах.

АРВАН ХОЁР. Холбооны санхүүжилт

- 12.1 Холбооны санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:
 - 12.1.1 МЗЭХ-ны гишүүдийн татвар;

- 12.1.2 Салбар холбоод болон хүндэт гишүүн, сайн дурынхны хандив;
 - 12.1.3 Төрийн ба төрийн бус байгууллагын үйл ажиллагааны оролцооны хэлбэрээр өргөх хандив;
 - 12.1.4 Иргэд аж ахуйн нэгж байгууллагуудын хандив;
 - 12.1.5 Зээлийн, өвийн болон төсөл, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс олгосон хөрөнгө;
 - 12.1.6 Төсөл хэрэгжүүлэх зорилгоор гадаад, дотоодын байгууллагаас олгосон мөнгөн хөрөнгө, тусламж;
 - 12.1.7 Дүрэмд заасан зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаанаас олсон орлого;
 - 12.1.8 Монгол Улсын хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.
- 12.2 Холбоо нь орлогоо зөвхөн дүрэмд заасан үйл ажиллагаанд зарцуулна.
- 12.3 Холбооны орлогоос ногдол ашиг хуваарилах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээрийн төлбөрийг төлөхийг хориглоно.
- 12.4 Холбооноос Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн болон иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчдэд эд хөрөнгө, хандив өгөхийг хориглоно.

АРВАН ГУРАВ. Дүрэмд өөрчлөлт оруулах

- 13.1 Удирдах зөвлөлийн гурваас доошгүй гишүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн дүрмийн өөрчлөлтийн төслийг УЗ-ийн хурлаар хэлэлцэн, дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 13.2 Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн тухай санал УЗ-ийн гишүүдийн 75 хувь нь дэмжсэнээр хүчин төгөлдөр болно.
- 13.3 Дүрмийн нэмэлт, өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлэх ажлыг ГА хариуцна.

АРВАН ДӨРӨВ. Холбоог татан буулгах

- 14.1 Холбоо дүрэмд заасан зорилгоо бүрэн хэрэгжүүлж дууссан тохиолдолд Холбоог татан буулгах тухай саналыг УЗ-өөр хэлэлцүүлж, санал дэмжигдвэл Холбооны БГХ-ыг хуралдуулан, татан буулгах шийдвэрийг гаргана.
- 14.2 Холбоог татан буулгах тухай шийдвэр нь БГХ-д оролцсон нийт гишүүдийн 75 хувь нь дэмжсэн тохиолдолд хүчин төгөлдөр болно.
- 14.3 Холбоог татан буулгах ажиллагааг Иргэний Хууль болон Төрийн бус байгууллагын тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулна.

- 14.4 Холбоог татан буулгах ажиллагааг УЗ-өөс сонгогдсон Татан буулгах комисс гүйцэтгэнэ.
- 14.5 Холбоог татан буулгаж зохих төлбөрийг хийсний дараа үлдсэн эд хөрөнгийг ижил төстэй зорилго бүхий төрийн бус байгууллагад шилжүүлэх, хэрэв тийм төрийн бус байгууллага байхгүй бол зорилгод нь нийцсэн үйл ажиллагаанд зарцуулна. Үлдсэн эд хөрөнгийг хувьдаа завьших, ашгийн төлөө байгууллагад шилжүүлэхийг хориглоно.
- 14.6 УЗ нь Холбоог татан буулгасан тухай шийдвэрээ 21 хоногийн дотор нийтэд мэдээлж, Хууль зүйн яаманд бичгээр мэдэгдэн, улсын бүртгэлээс хасуулснаар Холбооны үйл ажиллагааг дуусгавар болгосонд тооцно.

Монголын Залуу Эрдэмтдийн Холбоо

--ooOoo--